

Агуулга

1. Төслийн товч танилцуулга	2
Дээжид хийгдсэн шинжилгээ	5
Дээжинд хийгдсэн шинжилгээнүүд, тэдгээрийн үр дүн.....	6
Баяжуулах үйлдвэрийн бүтэц	7
Хүдэр баяжуулалт.....	7
Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын тооцоо.....	7
Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөлт	8
2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	9
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт	11
Сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	13
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
Болзошгүй эрсдлээс хамгаалах менежментийн төлөвлөгөө.....	15
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	15
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	17
Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	17
Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар	20

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

<i>Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага</i>	"Винкапитал" ХХК
<i>Төслийн байршил</i>	Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр (ТХБҮ) нь Хэнтий аймгийн Дархан суманд орших ба Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км, Бор-Өндөрөөс баруун хойш 18 км-т, Дорноговь аймгийн Айраг сумаас хойш 84 км; Говь сүмбэр аймгаас (Чойр хот) 90 км; Хэнтий аймгийн Дархан сумаас 24 км; Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас 58 км; Баргилтын төмрийн хүдрийн ордоос 1 км -ийн зайд байрлана
<i>Төслийн нэр</i>	Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр
<i>Төслийн хэрэгжих хугацаа</i>	ТХБҮ-ийн үйл ажиллагаа ТЭЗҮ, БОННҮ-ний хэрэгжилтийн хугацаанд тогтмол үргэлжилнэ

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, төмрийн хүдрийг шууд экспортолгүй хуурай соронзон баяжуулалтын аргаар баяжуулж 50-55%-ийн агуулгатай баяжмал үйлдвэрлэх, мөн төслийг хэрэгжүүлэх хугацаанд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, баяжуулах үйлдвэрийн үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

2022 онд 132.1 мян.тн 32 %-ийн агуулгатай хүдрийг баяжуулан 81.16 мян.тн төмрийн баяжмалыг гэрээгээр тохиролцсон нөхцлийн хүрээнд хамтрагч байгууллагад хүлээлгэн өгөв.

2022 онд Уул уурхайн судалгаа, шинжилгээний “Амблаб” ХХК-ийн мэргэжлийн баг баяжуулах үйлдвэрт ажиллаж үйлдвэрийн технологийн шат дамжлагуудаас дээжлэлт, сорьцлолтыг явуулан технологийн горимыг хянах болон металл авалтын үзүүлэлтүүдийн тогтоох ажлыг гүйцэтгэсэн.

2023 онд 100 мян.тн хүдрийг гэрээт аж ахуй нэгжүүдэд баяжуулан өгөхөөр зорин үйл ажиллагааг явуулж байна.

үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж байна.

"Вин Капитал" ХХК нь баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхийн тулд түүхий эд болох Баргилтын төмрийн хүдрээс дээж авч технологийн туршилтыг хийлгэх, үйлдвэрийн тоног төхөөрөмж, талбай, оффис, зоогийн газар, ажилчдын байрны угсралт суурилуулалт, автопүүний хэсэг, дэд бүтцийн ажлуудыг хийж дуусгасан ба өнгөрсөн онд бага хэмжээний баяжуулалт явуулж борлуулалт хийсэн байна.



Зураг 2 Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн ерөнхий зураг



Зураг 3 Баяжуулах үйлдвэрийн талбай дахь хүдрийн овоолго

Мөн сум орон нутагт зориулан "Вин Капитал" ХХК-аас Дархан сумын дунд сургуулийг засварлах ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал 100,000 тн бөгөөд 5 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөж байна.

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Дархан сумын Баргилтын төмрийн хүдрийн ордоос 1 км зайд байрлана. Мөн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдан авах, үйлдвэрийн байгууламжийн угсралт, суурилуулалтын ажлыг БНХАУ -ын компаниар гүйцэтгүүлж байгаа бөгөөд төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн туршилт шинжилгээ, ТЭЗҮ зэргийг дотоодын компаниудаар гүйцэтгүүлж байна. Баяжуулах үйлдвэрийн ЦДАШ татах цогц ажлуудыг гүйцэтгүүлэн улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Ус, дулаан хангамж

Баяжуулах үйлдвэр нь төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах тул үйлдвэрлэлийн усан хангамж шаардлагагүй бөгөөд зөвхөн хотхоны ажилчдын унд-ахуйн ус хангамж байна. "Винкапитал" ХХК нь унд-ахуйн усан хангамжийг гидрогеологийн гүний өрөмдлөг хийх газрыг сонгож худаг гаргах замаар шийдэх зайлшгүй шаардлагатай. “Винкапитал” үйлдвэрийг ажиллах хугацаанд баяжуулах үйлдвэрт нэгэн зэрэг 26 хүн ажиллах ба хотхоны усны хэрэглээг зөөврийн усаар хангаж байна.

Цахилгаан хангамж

2013 оны 11 сард олгогдсон техникийн нөхцөлийн дагуу "Вин Капитал" ХХК-ийн төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь "Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ"(БЗӨБЦТС) ТӨХК –ийн Говьсүмбэр - Бор-Өндөр - Дархан сум хүртэл татсан 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас салбарласан 1км урттай 35 кВ-ын агаарын шугам, 35/0.4кВ-ын ерөнхий бууруулах дэд станцаас үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчид тэжээгдэж байна.

Газар ашиглалт, газрын төлөв байдал

Төмрийн хүдрийг хуурай соронзон баяжуулалтын аргаар баяжуулах тул тоног төхөөрөмжийг баяжуулах үйлдвэрийн эзэмшлийн 10 га талбайн төв хэсэгт задгай талбайд тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулсан. Хяналтын хэсэг болон засварын хэсэг, мөн лаборатори болон ажилчдын хотхоныг сэндвич болон контейнерийн байгууламжаар шийдвэрлэсэн байна.

Зам харилцаа

"Вин Капитал" ХХК -ийн Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Дархан суманд орших ба Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км, Бор - Өндөрөөс баруун хойш 19 км-т, Дорноговь аймгийн Айраг сумаас хойш 84 км. Говь сүмбэр аймгаас (Чойр хот) 90км, Хэнтий аймгийн Дархан сумаас 24 км, Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас 58 км-т, Баргилт төмрийн хүдрийн ордоос 1 км зайд тус тус зайд байрлана.

Технологийн сонголт

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших “Винкапитал” ХХК-ний төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь 2018 оноос хойш ажиллаж байгаа Баргилтын ордын төмрийн хүдэрт хийгдсэн технологийн туршилтын үр дүнд тус ордын хүдрийг гурван шатны бутлалт, хоёр шатны хуурай соронзон баяжуулалтаар баяжуулах боломжтойг тогтоож, цаашид тус ордын хүдрийг энэхүү схемээр баяжуулахыг санал болгосон.


Дээжид хийгдсэн шинжилгээ

Баяжуулах үйлдвэрт боловсруулах хүдрийн найрлагыг тодорхойлох, хүдэр дэх ашигт болон хорт хольц, бусад эрдэс элементүүдийг тодорхойлох, тэдгээрийн агуулга болон тархалтыг тогтоох зорилгоор сар бүр гаалийн төв лабораторид шинжилгээ хийлгэдэг болно.

Хүснэгт 2 Туршилтад бэлдсэн дээжийн шигшүүрийн шинжилгээний үр дүн

Хүдрийн мөхлөгийн хэмжээ, (-0.074 мм-ийн агуулга)	Гарц, %	Төмрийн агуулга	Төмрийн тархалт, %
--	----------------	------------------------	---------------------------

-9.5		15.38	40.1	14.9
-3.9		29.31	42.56	30.2
-2.25		25.68	41.91	26
-1.35		17.21	41.52	17.3
-0.82		3.45	39.47	3.3
-0.58		3.11	39.24	2.9
-0.3		2.61	38.97	2.3
-0.15		1.57	38.58	1.5
-0.076		1	37.95	0.9
-0.074		0.68	37.86	0.7
Бүгд		100	41.39	100



Зураг 4 Туршилтад бэлдсэн схем

Дээжинд хийгдсэн шинжилгээнүүд, тэдгээрийн үр дүн.

Дээрх ижил төстэй ордуудын технологийн схемүүдээс ажиглахад төмрийн хүдрийг хуурай аргаар баяжуулалтад бэлтгэхдээ хүдрийн хатуулаг болон ашигт эрдсийн сулралын зэргээс хамааруулан задгай болон битүү циклээр гурван шатны бутлалт, 1-2 шатны шигшилт бүхий технологийн схемийг ихэвчлэн сонгож байна. Баяжуулах технологийн хувьд 2-3 шатны үндсэн, хяналтын болон цэвэрлэгээ хосолсон соронзон баяжуулалтаар 55-аас дээш хувийн агуулгатай баяжмал гарган авах боломжтой нь харагдаж байна. Иймээс тус ордын 32,17%-ийн агуулга бүхий төмрийн хүдрийг хуурай соронзон баяжуулалтын технологийг ашиглан баяжмалын агуулгыг 55%-д хүргэх боломжтой гэж үзэж байна

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн горим

Төмрийг хүдрээс ялгаж авах технологи нь хүдрийн соронзон шинж чанарт тулгуурласан байна. Харин эрдэс дэх төмрийн ширхэглэлийн хэмжээ, түүний тархалт, хүдрийн структур-текстурын өөрчлөлтөөс хамаарч соронзон ялгалтын арга нь хуурай ба нойтон гэсэн хоёр хэлбэрээр явагддаг. Баргилтын ордын орчимд гидрогеологийн нөхцөл сайтар судлагдаагүй буюу усан хангамж муу байгааг харгалзан үзэж төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах технологийг ашиглавал тохиромжтой гэж үзэж байна.

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн

Баяжуулах үйлдвэрийн бүтэц

Төмрийг хүдрээс ялгаж авах технологи нь хүдрийн соронзон шинж чанарт тулгуурласан байна. Харин эрдэс дэх төмрийн ширхэглэлийн хэмжээ, түүний тархалт, хүдрийн структур-текстурын өөрчлөлтөөс хамаарч соронзон ялгалтын арга нь хуурай ба нойтон гэсэн хоёр хэлбэрээр явагддаг.

Хүдэр баяжуулалт

Хүдрийн ширхэглэлийн хэмжээг багасгах зорилгоор бутлалтыг хийх ба энэ нь хүдэр боловсруулалтын бэлтгэл ажиллагаа нь болдог. Ямарваа хүдрийг буталж, шигшиж өгснөөр ашигт бүрдлүүд нь хоосон чулуулгуудаас салж, задарч өгөхөөс гадна ширхэглэлийн хувьд жигдэрч өгдөг. Ийм учраас ашигт малтмалыг боловсруулалт хийхийн өмнө заавал буталж шигших шаардлагатай. Төмрийн хүдэр нь хатуулаг өндөртэй (бөх батын коэффициент 18 хүртэл) учир голдуу гурван шатны бутлалттай схемээр буталдаг. Технологийн туршилтаар мөн Баргилтын төмрийн хүдрийг 3 шатны бутлалттай байхаар туршилтын үр дүн гарсан.

Хуурай соронзон ялгалт нь бараг бүх төрлийн магнетитын болон скарны төрлийн магнетит, ядуу агуулгатай титаномагнетитын хүдэрт өргөн хэрэглэгдэж байна. Скарны төмрийн хүдэр дэх ашигт эрдэс нь хоосон чулуулгаас сулрах сулрал нь гуравдугаар шатны бутлалтын дараа бүрэн нээгддэг бөгөөд энэ нь хуурай соронзон сепаратороор баяжуулах боломжийг бүрдүүлдэг.

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын тооцоо.

Хүдэр баяжуулах технологийн үзүүлэлтийн тооцоо

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь аль болох зардал багатай, ашигт эрдсийг бүрэн гүйцэд ялгах үндсэн зорилготой байхаас гадна хүдэр бутлан боловсруулах үйлдвэрийн хүчин чадал нь нийлүүлэх хүдрийн хэмжээнээс шууд хамааралтай байна. Төмрийн хүдрийг боловсруулалтад бэлтгэх дамжлага ба соронзон баяжуулалтын цехийн хүчин чадлыг ажиллах горимоос нь хамааруулан дараах томъёогоор тооцоолов.

Баяжуулах үйлдвэр жилийн хүчин чадал:

$Q_{ж} = 100000$ тн Бутлах цехийн хоногийн хүчин чадал:

$$Q_{х} = \frac{Q_{ж}}{190} = 526,3 \text{ тн/хон}$$

Бутлах цехийн цагийн хүчин чадал:

Үүнд:

$Q_{ц}$ - баяжуулах цехийн цагийн хүчин чадал, тн

$Q_{ж}$ - хүдэр боловсруулах үйлдвэрийн жилийн хүчин чадал, тн/жил N - жилд ажиллах хоногийн тоо

n - Ээлжийн ажиллах цаг t - Ээлжийн ажиллах цаг

k_x - баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ашиглалтын коэффициент

2023 онд манай компани нь гэрээний дагуу 100.0 мян.тн хүдэр баяжуулж өгөх төлөвлөгөөтэй байгаа ба дараах хүснэгтэд бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөөг үзүүлэв.

Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөлт

Хүснэгт 3 Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөлт

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2023 он
Баяжуулах хүдрийн хэмжээ			
1	Хүдрийн хэмжээ	мян.тн	100.0
2	Төмрийн агуулга	%	32.0
3	Хүдэр дэх төмрийн хэмжээ	мян.тн	32.0
Төмрийн хуурай баяжмал			
4	Баяжмал дахь төмрийн агуулга	%	52.15
5	Баяжмалын металл авалт	%	85.15
6	Баяжмалын гарц	%	52.25
7	Баяжмалын хэмжээ	мян.тн	52.25
8	Баяжмал дахь төмрийн хэмжээ	мян.тн	27.25
Хаягдал			
9	Хаягдал дахь төмрийн агуулга	%	9.95
10	Хаягдлын металл алдалт	%	14.85
11	Хаягдлын гарц	%	47.75
12	Хаягдлын хэмжээ	мян.тн	9.95
13	Хаягдал дахь төмрийн хэмжээ	мян.тн	4.75

2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товтч тодорхойлолт

Төслийн үндсэн баяжуулах үйл ажиллагаа битүүмжлэгдсэн барилга объектын дотор явагддаг тул үйлдвэрийн дуу чимээ, физик нөлөөлөл харьцангуй гадна орчинд харьцангуй бага, харин үйлдвэрийн ажилчдад үзүүлэх нөлөөлөл харьцангуй их. Усны хэрэгцээг зөөврийн усаар хийж эргэлтийн усан санд дамжуулан ашиглах ба усан санг нөхөн сэлбэх зорилгоор нэмэлт ус ашиглана. Гол сөрөг нөлөөлөлд усны нөөц ашиглалт, усан сангийн далангийн ашиглалт болон хүдэр хадгалах, тээвэрлэх ажиллагаанаас үүсэх тоос тоосжилт, баяжуулалтаас үүсэх хатуу хог хаягдлын хадгалалт, зайлуулалт, техникийн засвар үйлчилгээ, баяжмалын хадгалалт зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол хамаарна.

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, ургамал, гадаргын болон газрын доорх ус зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг орчны тохижилт, нөхөн сэргээлт зэргийг сайтар төлөвлөн хийж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулбал эерэг тал нь их.

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйл байх болно.

- Баяжуулах процессын дүнд үүссэн тоосонцорын бохирдол
- Хүдрийн хаягдлын овоолго 3,6 га талбайд үүсэх
- Ахуйн бохир ус үүсэх
- Автомашины шатахуун, тосны асгаралт
- Ажилчдын хөдөлмөр хамгаалалт, эрүүл ахуйн асуудлууд байх болно.

Дээрх үүсч буй сөрөг нөлөөлөлүүд нь төслийн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа болно. Хүснэгт 4-т голлох сөрөг нөлөөлөлийг төслийн үйл ажиллагаа болон байршилтай холбогдуулан схемчлэн харуулав.

Хүснэгт 4 Голлох сөрөг нөлөөллийн чанарын үнэлгээний шалгуур

Төвшин	Зэрэг	Тайлбар	
		Сөрөг нөлөөлөл	Шийдэл
V	Е – их	Тоосонцорын бохирдол ихээр үүсэх	Конвейерын хаалт хийх
III	Е – Их	Автомашины тос тослогооны бодисын тархалт	Үйл ажиллагааны хяналт, зохистой хэрэглээ
IV	Их	Хүдрийн хаягдлын овоолго үүсэх	Олборлолт явуулсан компанид нөхөн дүүргэлт хийх замаар буцаан нийлүүлэх
V	Дунд	Дуу чимээ, доргионы бохирдол	Шийдэх боломжгүй
V	Их	Ахуйн хатуу шингэн хаягдлын тархалт	Био технологийн сонголт
V	Дунд	Амьтны аймгийн дайжилт	Амьтны аймгийн нөхөн сэргээлтээр нүүлгэн шилжүүлэх
V	Дунд	Ургамал нөмрөгийн талхагдал, бохирдол	Аль болох бага талбай хамрах

Хог хаягдал, хэмжээ, зайлуулах хэлбэр

Үйлдвэрлэлийн хог хаягдал: “Винкапитал” ХХК-ийн төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрээс ашиглалтын хугацаанд хуурай хаягдал гарах бөгөөд хаягдлыг баяжуулах үйлдвэрийн эзэмшлийн талбайд газрын хэвгийг харгалзан тараан байршуулж, хэвгийжүүлж өгнө хэмээн ТЭЗҮ-д тусгажээ.

Хүснэгт 5 Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлын хэмжээ

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Орд ашиглалтын жилүүд					Нийт
		1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил	
Хүдэр	мян.тн	250000	250000	250000	250000	250000	1250000
Төмрийн анхдагч агуулга	%	32.17	32.17	32.17	32.17	32.17	160.85
Төмрийн хэмжээ	мян.тн	80425	80425	80425	80425	80425	402125
Хаягдлын гарц	%	48.52	48.52	48.52	48.52	48.52	242.60
Хаягдал гаргалт	мян.тн	121300	121300	121300	121300	121300	606500

Дээрх хүснэгтэнд тооцсны дагуу нийт 606500 тн хаягдал гарна гэвэл стандартын дагуу 6 м-н өндөртэйгээр хаягдлын овоолго хийвэл 36100 м² буюу 3.61 га талбайг шаардлагатай болно /хүдрийн эзэлхүүн жинг -2.8 гр/см³-р авав/.

Ахуйн хатуу хог хаягдал: Төслийн үйл ажиллагаанд нийт 30 хүн ажиллах ба тэдний ахуйн гаралтай хатуу хог хаягдлын хэмжээг тооцоходоо нэг хүнээс хоногт 2 кг хог хаягдал гарна гэдэг жишиг хэмжээг үндэслэн тооцоход 60 кг (30 х 2кг) буюу 1 сард 30 хон х 60 кг = 1800 кг /1,8тн/ орчим хатуу хог хаягдал гарахаар байна.

Ахуйн хог хаягдлын цэгийг үйлдвэрийн талбайн баруун хойд хэсэгт 3х2 х 1,5 м-н харьцаатай нүхэнд хийн цуглуулж байв.

Ахуйн шингэн хаягдал: Төслийн үйл ажиллагааны үед ахуйн зориулалттай хоногт нийт 0.9 м³, жилд 244.8 м³ ус хэрэглэхээр тооцоо гарч байна. Үүний 30%-ийг бохир ус болно гэж үзвэл хоногт 0.27 м³, жилд 73.44 м³ бохир ус гарахаар тооцоо гарч байна.



Зураг 5 Ажилчдын ахуйн жорлон

Төслийн явц дахь агаарын гол бохирдуулагч эх үүсвэр нь хуурай баяжуулалтын үйл явц болон үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдах хүнд машин хөдөлгөөнөөс үүсэх тоос шороо байх болно.

Хүснэгт 6 Агаарын бохирдлын үүсгэгчид

№	Хөрөнгийн нэр	Марк	Тоо хэмжээ, ш
1	Автосамосвал	STEYR	3
2	Дугуйт ачигч		1
3	Суудлын машин	Жип	2
4	Өөрөө буулгагч		1
5	Усны машин		1
	Нийт		8

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Винкапитал” ХХК нь 2023 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт **4.295 сая төгрөг** зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь уулын ажлын болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөв.

Хүснэгт 7 Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгдсэн дүн

№	Арга хэмжээ	Зардал, сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	300 000
2	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1 600 000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	700 000
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	400 000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	400 000
9	Орчны хяналт шинжилгээ	895 000
10	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	-
Нийт зардал, сая.төг		4 295 000

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
1	Агаарын чанар								
	Ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Машин механизмаас гарах утаанд хяналт тавих	Төсөлд хэрэгжүүлэхэд ашиглах бүх дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, машин механизм	ш	Үйл ажиллагааны зардалд		2023 оны турш тогтмол		Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2009 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавих		-		Үйл ажиллагааны зардалд		2023 оны турш тогтмол			
Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг сайжруулах		ш		2023 оны турш тогтмол	100 000	2023 оны турш тогтмол			
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц								
	Төслийн үйл ажиллагааны ус хэрэглээнээс үүсэх газрын доорх усны түвшний бууралт, газрын доорх усны нөөц багасах	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Гүний усанд	-	Үйл ажиллагааны зардалд		2023 онд		Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
		Үйлдвэрлэлийн үед ашиглах усны төлбөр тооцоог холбогдох байгууллагад төлөх		шоо метр	-	Гэрээний дагуу төлбөр төлөх		2023 онд	
3	Хөрс, ургамлан бүрхэвч								
	Уурхайн нөлөөллийн бүсийн хүрээний зам талбайн тохижилт муугаас үүдэн	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Төслийн ойр орчин	-	-	-	-	2023 онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль •Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн

“ВИНКАПИТАЛ” ХХК-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМРИЙН ХҮДЭР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	машин техник, хүний хөлөөр хөрсөн бүрхэвч доройтох	Үйлдвэрлэлийн орчимд ногоон байгууламж байгуулах, арчлах	үйлдвэр орчимд	м кв	-	-	200 000	2023 онд	шаардлага MNS 5915:2008, •Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага MNS 5916:2008, •Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918: 2008, •Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс MNS 4919: 2000, • Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага MNS 4920: 2000,
4	Амьтны аймаг								
	Ан амьтан дайжих, тоо толгой хорогдох	Ан амьтны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-аас танилцуулах самбар, постер хийх	Төслийн талбай орчмын ан амьтад	ш	Үйл ажиллагааны зардалд			2023 онд	Амьтны тухай хууль
	Нийт						300 000		

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас халцарч зулгарсан хөрсөн гадаргуугийн хэмжээг багасгах	БОННУ-ний шаардлагын дагуу ашиглалтгүй талбайн хөрсийг сайжруулж ургамалжуулах	га	Эдэлбэр газрын 0.1 га талбайд	-	600 000	2023 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
2	“1 тэрбум мод” үндэсний хөтөлбөр	Сум орон нутгийн хэмжээнд ойжуулах талбайд элсний нүүдлийг сааруулах, зогсоон барих зорилгоор мод тарих	Төв аймгийн ойжуулах талбайд	250 ш	4000	1 000 000	2023 онд	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол
	Нийт					1 600 000		

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	2022 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнл төлөвлөсөн 5 га талбайн нөхөн сэргээлтийн ажил	Хаягдсан газрын нөхөн сэргээлт	5	Га	Үйл ажиллагааны зардалд		2023 онд	
Нийт								

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нөхөн олговор олгох арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1								
2								
3								
Нийт					-			

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөлийн бүсэд яман нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	Археологийн дурсгал							
2	Палеонтологийн дурсгал							
Нийт								

Болзошгүй эрсдлээс хамгаалах менежментийн төлөвлөгөө

Үйлдвэрлэлтийн үйл ажиллагаанд ямарваа нэг химийн бодис ашигладаггүй нь химийн бодисоос үүсэх эрсдэлгүй тул Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөөг боловсруулж өглөө.

Хүснэгт 8 Болзошгүй эрсдлээс хамгаалах зардал

№	Болзошгүй аюул, осол, нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Болзошгүй эрсдлээс хамгаалсан сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	2	100 000	200 000	2 удаа	Гамшгаас хамгаалах тухай, 27-р зүйл Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
2	Гал түмрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Аюул тохиолдсон газрыг хамгаалалтанд авч, хор аюулын таних тэмдэглэгээг байршуулж холбогдох мэргэжлийн байгууллагыг дуудан туслалцаа авах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардал		2023 онд		
3	Шатах тослох материалын асгаралт	Галын хорыг шалгаж, шаардлага хангахгүй хорыг сольж, шинэчлэн цэнэглэж байршуулах	Төслийн хүрээнд	10	50 000	500 000	2023 онд	
		Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардал		2023 онд		
Нийт						700 000		

3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
1	Ахуйн	Хог хаягдлын төрөл тус бүрээр ангилан ялгаж, түр хадгалах цэгийг хашаа хамгаалалт хийж, тохижуулах	Уурхайн тосгон	-	Үйл ажиллагааны зардалд		2023 онд	Хог хаягдлын тухай хууль, 10-р зүйл Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дугаар сарын 09-	
		Дахин ашиглагдах хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх. /хуванцар сав, шингэн хаягдал...../	Уурхайн тосгон	-	Үйл ажиллагааны зардалд		2023 онд		

“ВИНКАПИТАЛ” ХХК-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМРИЙН ХҮДЭР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		Шаардлага хангасан цэгт төвлөрүүлж орон нутагтай хог ашиглалтын гэрээ хийж зайлуулна.	-	-	-	-	200 000	2023 онд	ны өдрийн А-116 дугаар тушаалын хавсралт
2	Үйлдвэрлэлийн	Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг чөлөөт урсацаас чөлөөлж нэг цэгт төвлөрүүлэх	Уурхай	кг	Үйл ажиллагааны зардалд			2023 онд	MNS 5850:2019 MNS 5344 : 2011 MNS ISO 11074-1 : 2001
3	Аюултай	Аюултай хог хаягдлын цэгийн талбайг цэвэрлэж засаж, тохижуулах, асгаралт үүсэхээс хамгаалах	Аюултай хог хаягдлыг хадгалах талбайд	М кв	Үйл ажиллагааны зардалд			2023 онд	Хог хаягдлын тхай хууль 22, 23, 24-р зүйл,
		Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний явцад гарсан аюултай хог хаягдлыг контейнерт хадгалах /аккумулятор, баттерей Ашиглагдсан шатах тослох материал, тос маслын сав г.м./	Төслийн хүрээнд	Кг	Үйл ажиллагааны зардалд			2023 онд	
		Ашиглагдсан шатах тослох материалыг битүү саванд хадгалж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.	-	л	-	-	200 000	2023 онд	
Нийт							400 000		

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь 2023 он			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Сар	Сар	Сар		
	1.	2.	3.	4.	5.	6.	7.
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг ажилчдад хийх	200 000	6 сар	10 сар	-	Байгаль орчны мэргэжилтэн	Галын аюулгүй ажиллагааны дүрэм Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Байгаль орчныг хамгаалах, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг уурхайн кэмп, төв хаалга, үйлдвэрлэлийн бүсэд байрлуулах, шинэчлэх	200 000				Байгаль орчны мэргэжилтэн	
3	БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу ТЖБОМТ-г жил бүр боловсруулж БОАЖЯ-аар батлуулах	Үйл ажиллагааны зардалд		12 Сард			
4	ТЖБОМТ – г өмнөх жилийн 12-р сард багтаан БОАЖЯ-аар батлуулах, ТЖБОМТ- ний биелэлтийн тайланг жилийн эцсээр 11-р сард багтаан боловсруулж орон нутгийн байгаль орчны газар болон ажлын хэсэгт танилцуулан дүгнүүлж байх	Үйл ажиллагааны зардалд					
Нийт		400 000					

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Винкапитал” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

“Винкапитал” ХХК -ийн Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Төмрийн хүдэр баяжуулах үйлвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” -ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус компани нь бүрэн хариуцна.

Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЛ, Геологийн төв лаборатори, Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори болон УСУГ-н усны лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1.	2.	3.	4.	5.	6.	
1	Агаарын чанар						
	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд / Уурхайн олборлолт болон үйлдвэрийн ойролцоо талбайд/	8 сар	Жилд 1 удаа 2 цэгт	Томилолт - 40.0 Шинжилгээний зардал – 100.0	250 000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Байгаль хамгаалал. Агаар мандал. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2000 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	үйлдвэрийн ойролцоо талбайд 2 цэг	8 сар	Жилд 1 удаа 2 цэгт	Шинжилгээний зардал – 200.0	400 000	
2	Хөрсний бохирдол						
	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Төслийн талбайд 3 цэг сонгох - ШТМ түгээх цэгийн орчим - Хог хаягдал түр хадгалах цэгт - кемп орчим	8 сар	Жилд 1 удаа 3 цэгт	Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -25.0 төг,	75 000	MNS 3307:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
	Хүнд металлын агууламж	Дээрх 3 цэгт	8 сар	Жилд 1 удаа 3 цэгт	хүнд металлын шинжилгээ 1 дээж- 40.0 төг	120 000	

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Баримтлах стандарт, арга, аргачлал
							MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	Усны шинжилгээ						
	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Гүний худаг	8 сар	Жилд 1 удаа	40.0 төг	50 000	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
	Нийт					895 000	

Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 10 Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (төгрөг)	Хариуцан байгуулах тушаалтан/ажилтан	зохион албан	Зохион байгуулах газар
	1.	2.	3.	4.	5.	6.		7.
1	Иргэдийн Нийтийн Хуралд	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	10 сард	Үйл ажиллагааны зардалд	Байгаль мэргэжилтэн	орчны	Дархан сум
2	Аймгийн байгаль орчны газарт	хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр		11 дүгээр сарын 01-ний дотор	Үйл ажиллагааны зардалд	Байгаль мэргэжилтэн	орчны	Хэнтий аймаг
3	Байгаль Орчин Аялал Жуулчлалын яам	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт		Жилийн эцэст (12.01-нд)	Үйл ажиллагааны зардалд	Байгаль мэргэжилтэн	орчны	Улаанбаатар хот